



ЭЙР КОНДИЦИОНЕР (хананд байрлах зориулалттай)



MIDEA Фирмийн хананд байрлах зориулалттай Эйр Кондиционер нь 13-51м² хүртэлх талбайг хөргөх, халаах, агаар цэвэршүүлэх, агаарын эргэлт хийх зориулалтайгаар ашиглагдана. Ахуйн болон, гэр, оффис, зочид буудал, эмнэлэг лаборатори, бага хэмжээний хурлын өрөөнд ашиглах боломжтой. Тус төхөөрөмж нь хамгийн сүүлийн үеийн технологээр хийгдсэн бөгөөд, хэлбэр дизайн, дуу чимээ багатай, хэрэглэхэд хялбар алсын удирдлагатай. Европ стандартыг хангасан байгаль орчинд ээлтэй, хүний биед хоргүй хийгдсэнээрээ онцлог. Манай орны байгалийн эрс тэс уур амьсгалд зориулагдан тусгай захиалгаар хийгдсэн болно.



ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Model/ Загвар | Capacity Хүчин чадал | | Electric Parts Цахилгааны хэсэг | | Performance Гүйцэтгэл | | | Net Dimension & Weight Цэвэр хэмжээ ба цэвэр жин | | | Applicable Area Санал болгох талбай |
|---------------|--------------------------------------|-----|---|-------------------------------|-----------------------|------|--|---|------------------------------------|-------------------------------------|--|
| | Cooling / Heating Хөргөх / Халаах | | Voltage, Frequen- cy, Phase Хүчдэл, Давтамж, Фаз | Power Input Хүчдэл орох | EER | COP | Noise Level Дуу чимээний түвшин | Дотор гадна Indoor Out- door | Net weight Цэвэр жин | Indoor outdoor Дотор гадна | |
| | Btu/h | HP | | | | | | | | | |
| | | | V~,Hz,Ph | W | Btu/ W.h | W/W | m ³ /h | dB(A) | mm | | |
| MSAF-09HRN1 | 9000/10000 | 1 | 220-240, 50, 1 | 815/805 | 3.24 | 6.64 | 600/500/350 | in 41/37/29 out 55 | in-750x198x280 out-780x250x540 | 8/10 | 12-18 |
| MSAF-12HRN1 | 12000/13000 | 1.5 | 220-240, 50, 1 | 1085/1050 | 3.24 | 3.63 | 700/570/460 | in 43/38/31 out 56 | in-835x198x280 out-780x250x540 | 9/11 | 16-23 |
| MSAF-18HRN1 | 18000/19000 | 2 | 220-240, 50, 1 | 1640/1540 | 3.22 | 3.61 | 1150/830/650 | in 50/41/33 out 56 | in-990x218x315 out-845x320x700 | 12.5/15.5 | 24-40 |
| MSAF-24HRN1 | 24000/25000 | 3 | 220-240, 50, 1 | 2190/2025 | 3.21 | 3.62 | 1400/1250/1150 | in 50/47/37 out 60 | in-1186x258x340 out-946x410x810 | 16/20 | 32-50 |

ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ ФУНКЦУУД

1w=3.42BTU/H (BTU-British Thermal Unit) 2800w=1HP (HP-Horse Power)


АЖИЛЛАХ НӨХЦӨЛ:

ХӨРГӨЛТИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН ӨВӨЛ,
ЗУНЫ АЖИЛЛАХ ГОРИМ

SPLIT - загварын ажиллагаа нь - 5°C -с 48°C -ийн
градуст тогтвортой ажилладаг.



SPLIT - загварын ажиллагаа нь - 10°C -с 24°C -ийн
градуст тогтвортой ажилладаг.



Био шүүлтүүр
Тусгайлан гаргаж авсан биологийн энзим болон эко шүүлтүүрээс бүрдэх био шүүлтүүртэй. Эко шүүлтүүр нь агаарт үүссэн бишил тос, тоосонцорыг шүүж, бактери, мөөгөнцөр, микробыг идэвхгүй болгох үйлчилгээтэй. Биологийн энзим нь бактерийн эсийн ханыг уусгах замаар бактери устгадаг тул орчны агаарт бохирдол дахин үүсэх тохиолдлыг үгүй болгодог.

Мөнгөжүүлсэн ионт шүүлтүүр
Нано технологийн аргаар гаргаж авсан мөнгөжүүлсэн ионы шүүлтүүрт суулгаж өгснөөр бактерийн дотоод бүтцийг устгаж, элементүүдийг нь шингээх замаар бактерийг устгах, маш бага нягтшилтайгаар идэвхгүй болгох үйлчилгээтэй.

2 Чиглэлт агаарын урсгал
Халуун, хүйтэн агаарын нягтшил өөр өөр байдаг. Төхөөрөмж хүйтэн агаарыг хөндлөн чиглэлд, халуун агаарыг босоо чиглэлд үлээдэг учир өрөөний температурыг илүү тогтвортой, уур амьсгалыг тав тухтай болгодог.

Амралтын горим
Энэ горимд төхөөрөмж сэрүүчлүүлэх болон халуунаар үлээх температурыг зөвхөн 2 цагт цаг бүр автоматаар 1°C-р нэмэх, эсвэл хасах бөгөөд цааш 5 цагийн турш нэг түвшинд барьсаны дараагаар унтарна. Энэ нь эрчим хүчний хэмнэлтэйгээс гадна шөнийн цагт таны тэе гухыг хангана.

Ионжуулагч
Ой мод, хүрхнээний орчимд байнга байдаг ионууд нь биеийн цусны эргэлтийг системийг идэвхжүүлж, уушгины үйл ажиллагааг сайжруулна, хатгаа зэрэг амьсгалын замын өвчнөөс сэргийлдэг.

Автоматаар дахин ачааллах
Цахилгаан тасрах зэрэг гэнэтийн тохиолдлоор төхөөрөмж унтраад хэсэг хугацааны дараа цахилгаан ирэхэд өмнөх тохиргоо автоматаар дахин ачаалагдана.

С витамин шүүлтүүр
Энэ шүүлтүүр нь агаарт С витамин тараах тул арьсыг зөөлрүүлж, стресс бууруулдаг. Энэ шүүлтүүрийг ойролцоогоор 2 жил ашиглана.

LCD дэлгэц
Дотор байрлах төхөөрөмжийн хяналтын самбар нь LCD дэлгэцтэй.

10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 83/2

77118081

Вэб сайт: www.sinus-dochi.mn

И-мэйл: contact@sinus-dochi.mn, sales@sinus-dochi.mn